



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/1239

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20.8, Эрүүл мэндийн яамны “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ



Эрүүл мэндийн сайдын 2017 оны  
06 сарын 15 өдрийн 1/2 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НӨМЭЛТЭЭР ОЛГОХ  
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
<b>Шинээр олгох</b>			
1	Хүннү ХХК- Тэрэлж Бумбат сувилал	Сувиллын тусламж үйлчилгээ	3 жил
2	Цэргийн төв эмнэлэг	Тусгай эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
3	Адхими селис клен ферпект ХХК	Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Манал Цогт ХХК	Ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл үйлдвэрлэх	3 жил
5	Цагаан овоо фарм ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	Эм ханган нийлүүлэх	3 жил
7	Тайёо таун корпораци	Эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
8	Аму мед ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
9	Си Эл Даблю ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил
<b>Нэмэлтээр олгох</b>			
1	Мон-Интра ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эд импортлох	3 жил
2	Ач-Үр ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Био системс ХХК	Лабораторийн урвалж, оношлуур ханган нийлүүлэх, импортлох	3 жил

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 06 сарын 15-ны өдрийн  
Н... дугаар тушаалын 2 дугаар  
1239 хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг	Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ
2	Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи үйлдвэрлэлийн корпораци	Эм ханган нийлүүлэх
3	ЖЖ меракл ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх
4	Аму-Увс ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
5	Тайёо Таун ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх